

**“АРХУСТ ШУНХЛАЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ
НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2010 оны 4 дүгээр сарын
14-ний өдөр

Дугаар 1

Төв аймаг

Хувь нийлүүлэгчдийн хурлын ирцийн тухай
болон хурлыг хучин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Энэ удаагийн хуралд 72530 саналын эрх бүхий 72530 ширхэг хувьцааг эзэмшиж буй 7 хувьцаа эзэмшигч биеэр хүрэлцэн ирсэн нь нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 95,6 хувь нь болж байгааг хуралд оролцогчдод болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 70.1 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 95,6 хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгааг үндэслэн компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг хучин төгөлдөрт тооцох саналыг хувь нийлүүлэгчдийн хуралд танилцуулсугай.



ТООЛЛОГЫН
КОМИССИЙН ДАРГА

/Б.БИЛГҮҮН/

**“АРХУСТ ШУНХЛАЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ
НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2010 оны 4 дүгээр сарын
14-ний өдөр

Дугаар 2

Төв аймаг

Санал хураах хуудсыг тоолсон дунгийн тухай

Компанийн тухай хуулийн 72 дугаар зүйл, санал хураах хуудсыг тоолсон дунг хэлэцээд ТОГТООХ НЬ:

1. Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал хураасан дун дараах байдалтай байгааг хуралд оролцогчдод мэдээлсүгэй:

1.1. Компанийн өнөөгийн байдлын тухай мэдээлэл болон үйл ажиллагааг сэргээх төслийг батлах

зөвшөөрсөн 72530 ширхэг хувьцаа буюу 100 хувь, зөвшөөрөөгүй 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь

1.2. Компанийн дүрмийг батлах

зөвшөөрсөн 72530 ширхэг хувьцаа буюу 100 хувь, зөвшөөрөөгүй 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь

1.3. Компанийн дотоод журмуудыг сайшаах

зөвшөөрсөн 72530 ширхэг хувьцаа буюу 100 хувь, зөвшөөрөөгүй 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь

1.4. Компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдах шийдвэрийг батлах

зөвшөөрсөн 72530 ширхэг хувьцаа буюу 100 хувь, зөвшөөрөөгүй 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь

2. Санал хураасан асуудал тус бүрээр хувьцаа эзэмшигчдээс өгсөн зөвшөөрсөн санал нь Компанийн тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасан хурлын шийдвэр хучин төгөлдөр болох хувьд хүрсэн тул хурлын шийдвэрийг батлуулах саналыг хувь нийлүүлэгчдийн хуралд танилцуулсугай.



Б.БИЛГҮҮН

/Б.БИЛГҮҮН/

**“АРХУСТ ШУНХЛАЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ
НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2010 оны 4 дүгээр сарын
14-ний өдөр

Дугаар 3

Төв аймаг

Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 72.1.3 болон 77.4 дугаар зүйл, санал хураах хуудсаар кумулятив аргаар өгсөн саналыг тоолсон дүнг хэлэцээд ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгуулахаар нэр дэвшсэн хүн тус бүрээр кумулятив аргаар өгсөн саналын тоо нь дараах байдалтай байгааг хувь нийлүүлэгчдийн хуралд мэдээлсүгэй.

| | |
|-------------------|-------|
| 1.1.Д.Амар | 72530 |
| 1.2.Б.Анар | 72530 |
| 1.3.Г.Нарангэрэл | 72530 |
| 1.4. Ц.Оюумаа | 72530 |
| 1.5. Ц.Сарантуяа | 72530 |
| 1.6. Ц.Баяраа | 72530 |
| 1.7.Г.Алтаймаа | 72530 |
| 1.8.Б.Отгонтуяа | 72530 |
| 1.9.Д.Нанжинчимэг | 72530 |

2. Компанийн хянан шалгагчаар нэр нь дэвшсэн С.Сэлэнгийг сонгох эсэх асуудлыг санал хураах энгийн аргаар санал хураахад нийт саналдын эрхтэй хувьцаа эзэмшигчид 100 хувь зөвшөөрсөн санал өгсөн болохыг хувь нийлүүлэгчдийн хуралд мэдээлсүгэй.



Б.Индуул

/Б.БИЛГҮҮН/

**"АРХУСТ ШУНХЛАЙ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ
НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2010 оны 4 дүгээр сарын
14-ний өдөр

Төв аймаг

Төв аймийн Архуст сумын "Архуст шунхлай" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 13 цагт Төв аймийн Эрдэнэ сумын Соёлын төвд эхэллээ. Хуралд хувьцаа эзэмшигч Д.Зандансүрэн, Б.Уламбаяр, Б.Содномцог, С.Эрдэнэбилэг, С.Батцогт, Ч.Базардорж, Б.Алтангаяа нар оролцоо. Эдгээр хувьцаа эзэмшигч тус бурийн эзэмшиж байгаа хувьцааны тоо дараах байдалтай байна.

| | | | |
|------------------|-------|------|--------|
| 1.Б.Содномцог | 1175 | буюу | 1,54% |
| 2.Б.Уламбаяр | 11485 | буюу | 15,14% |
| 3.Д.Зандансүрэн | 10503 | буюу | 13,84% |
| 4. С.Эрдэнэбилэг | 14663 | буюу | 19,33% |
| 5.С.Батцогт | 14838 | буюу | 19,33% |
| 6. Ч.Базардорж | 14719 | буюу | 19,39% |
| 7. Б.Алтангаяа | 5147 | буюу | 6,78% |
| | 72530 | | 95.6% |

Эхлээд хурлын тооллогын комиссын даргаар Б.Билгүүнийг, хурлын даргаар хувьцаа эзэмшигч Д.зандансүрэнг тус тус сонголоо.

Хурлын дарга Д.Зандансүрэн хурлын ирцийг танилцуулахыг Б.Билгүүнээс хүсэхэд хуралд хувьцаа эзэмшигч 7 гишүүн биеэр хүрэлцэн ирсэн бөгөөд хурлын ирц 95,6 хувьтай байгааг мэдэгдлээ.

Компанийн тухай хуульд заасан хурал хүчин төгөлдөр болох хурлын ирц хурсэн тул хурлын үйл ажиллагааг эхлэх боломжтой болсныг хурлын дарга мэдэгдээд хурал нээснийг зарлалаа.

Д.Зандансүрэн: Компанийн энэ удаагийн хурлаар хэлэлцэхээр товлосон дараах асуудлуудыг хэлэлцэнэ.

1. Компанийн өнөөгийн байдлын тухай танилцуулга

2. Компанийн үйл ажиллагааг сэргээх төсөл
3. Компанийн дотоод журмуудыг хэлэлцэн батлах
4. Компанийн дурмийн шинэчлэсэн найруулгыг батлах
5. Компанийн ТУЗ –ийг болон хянан шалгах зөвлөлийг сонгох
6. Компанийн нэр, байршлыг өөрчлөх

Одоо компанийн захирал Ч.Базардорж компанийн өнөөгийн байдлын талаар танилцуулга, мэдээлэл хийнэ.

Манай компани Архустын сангийн аж ахуйн суурин дээр байгуулагдсан. Архустын сангийн аж ахуй нь анх 1955 онд байгуулагдсан. Шинээр байгуулагдсан сангийн аж ахуйг ажиллах хүчинээр хангах зорилгоор Завхан, Говь-Алтай аймгаас залуучуудыг ажилчнаар элсүүлэн авч, анх сангийн аж ахуйг бурдуулж байсан.

1955 онд Архустын сургууль комбинатад 4-р ангийн боловсролтой 100 гаруй залуучуудыг элсүүлэн тракторч, комбайнч мэргэжил эзэмшигүүлэн улмаар Архуст сумын Шунхлайн хөндийд 10 шинэ трактортайгаар атрын анхны шанг татаж байсан түүхтэй.

Мөн түүнчлэн сангийн аж ахуйд өндөр ашиг шимтэй каракуль хонь өсгөж эхэлсэн. Улмаар малын тэжээл, төмс, хүнсний ногоо тарьдаг САА болон өргөжсөн.

Монгол улын өмч хувьчлалын хуулийн дагуу 1992 оны 1 дүгээр сарын 3-ний өдөр Төв аймгийн өмч хувьчлалын комиссын шийдвэрээр хувьчлагдсан. Хувьчлах зорилгоор хувьцаат компани болгон өөрчлөн байгуулах тухай шийдвэрт компанийн дурмийн сангийн хэмжээг 7,587,4 мянган төгрөгөөр тогтоож, нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 75874 ширхэг хувьцаа гаргасныг Монголын хөрөнгийн бирж дээр ХОЭБ-ээр 100 хувь худалдсан.

1997 оноос компанийн хувьцааны 95 гаруй хувийн багцыг одоо энэ хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигч та бид эзэмшин, компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг бурдуулэн, компанийг удирдан ажиллах болсон билээ.

Сүүлийн жилүүдэд цаг агаарын таагуй нөхцөлөөс болоод малаа үндсэндээ бараад байгаа бөгөөд эргэлтийн хөрөнгөгүй, банкнаас зээл авах

барьцаа хөрөнгөгүйн улмаас компанийн үйл ажиллагаа үндсэндээ зогсоод байна.

Ялангуяа сүүлийн 3 жилд үйл ажиллагаа явуулаагүй байгаа билээ. 2006 онд сүүлийн удаа санхүүгийн тайлан гаргаж, аймгийн санхүү, татварт тушааснаас хойш Х баланс гаргаж байгаа.

Хэдий тийм боловч бид компания улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлсэн, үйл ажиллагаагаа сэргээн явуулах арга замыг эрэлхийлсээр ирсэн.

Гэсэн хэдий боловч санхүүгийн хувьд үйл ажиллагаагаа сэргээх боломжгүй байсаар өнөөг хүрээд байна.

Санхүүгийн зохицуулах хороо 2008 онд 77 дугаар тогтоол гаргаж, 160 гаруй компанийн арилжааг зогсоосны нэгэнд манай компани орсон байна. Олон жил хурлаа хийгээгүй болохоор ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болжээ. Мөн манай компанийн бүх хөрөнгө үрэгдсэн гэж бүртгэгдсэн байдаг юм байна. Одоо уг Хорооноос хөрөнгөө үрэгдүүлж, үйл ажиллагаа нь зогсон компанийн удирдлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр холбогдох арга хэмжээ авч байгаа юм байна.

Бид хэдийгээр компанийн хөрөнгийн зарж үрээгүй ч гэсэн тэжээлийн тариалалт, мал аж ахуй маань өөрөө байгалийн эрсдлээр үрэгдэж үгүй болсныг бүгдээрээ л мэдэж байгаа. Одоо компанийд эвдэрч, ашиглах боломжгүй болсон утрам, одоо хоосон байгаа, ашиглавал ихээхэн зардал гаргаж засвар хийх шаардлагатай конторын барилга зэргээс өөр хөрөнгө байхгүй. Эдгээр хөрөнгийн балансын үнэ нь 7,9 сая төгрөг байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай нэг компаниас Халимаг улс цөлжилттэй тэмцэхдээ ашигласан гэсэн хөрс голдоггүй, ус бага шаарддаг нэг төрлийн тэжээлийн ургамал тариалан туршилт хийж болох юм гэсэн санал гарсны дагуу компанийнхаа үйл ажиллагааг сэргээх төсөл боловсруулах, улмаар үнэт цаасныхаа арилжааг сэргээх хүсэлтээ СЗХ-д хургуулэх, ТУЗ, хянан шалгагчаа шинэчлэн сонгох, дүрэм журмаа шинэчлэх зэрэг асуудал хэлэлцэхээр энэ удаагийн хурлыг зарлан хуралдуулж байна. Компанийн өнөөгийн байдал үндсэндээ иймэрхүү байна. Асуух зүйл байвал хариулья гэлээ.

Энэ асуудлаар ямар нэг асуулт гарсангүй.

Д.Зандансүрэн: Одоо Евроази компани бидний хүсэлтээр боловсруулж өгсөн төслийг хэлэлцэх асуудалдаа орьё. Та бүхэнд өмнө нь тараасан байгаа. Том төсөл учир уншиж танилцуулах шаардлагагүй байх. Харин асуултаа асуугаад санаалаа хэлэлцье.

Б.Содномцог: Сайхан төсөл болжээ. Одоо хэрэгжүүлэх л шаардлагатай байна. Төсөл хэрэгжүүлэхэд гаргах санхүүжилтийн асуудлыг энэ компани шийдэх юм уу?

Ч.Базардорж: Тиймээ. Хөрөнгө оруулалт хийнэ гэсэн. Гэхдээ хүний хөрөнгөн дээр хөрөнгө оруулалт хийгээд явна гэж юу байх вэ, арилжаа сэргээсний дараа хувьцааны тодорхой хувийг санхүүжилт хийх этгээд худалдан авах юмуу, эсхүл нэмж хувьцаа гаргахыг бид зөвшөөрсөн тохиолдолд л хөрөнгө оруулалт хийхээр урьдчилсан байдлаар тохиролцоод байгаа. Компанийн эдэлбэр газрыг сумын засаг захиргаа хураан аваад өөр этгээдэд шилжүүлсэн байгаа. Энэ асуудлыг бас шийдвэрлэж өгөх зэрэг биднээс шалтгаалах асуудал олон байгаа.

Юуны өмнө компанийн арилжааг сэргээх эсэхээс хөрөнгө оруулалт хийгдэх асуудал шалтгаалах болоод байна.

Өөр асуулт гаргаагүй учир дараагийн асуудалд орлоо.

Д.Зандансүрэн: Одоо компанийн дүрмийн шинэчлэсэн найруулга, компанийн засаглалын дотоод журмуудыг хэлэлцэн батлах асуудалдаа орьё.

Дүрмийн болон журмуудын төслийг урьдчилан тараасан. Асуулт байвал асуугаад явья. Бүгдээрээ танилцсан учраас асуулт алгаа гэцгээв.

Д.Зандансүрэн: Дотоод журмуудыг сайшаагаад шинээр сонгогдох төлөөлөн удирдах зөвлөлөөрөө батлах нь зүйтэй гэсэн саналыг төсөл боловсруулсан баг зөвлөсөн. Учир нь дотоод журам батлах нь Компанийн тухай хуулийн 76.1.13-т заасны дагуу ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаардаг юм байна.

Ийм учраас хувь нийлүүлэгчдийн хурлаараа журмуудыг сайшаасан шийдвэр гаргаад ТУЗ-ийн анхны хуралд оруулах уу гэв. Хувьцаа эзэмшигчид бүгд сайшаалаа.

Харин компанийн дүрмийн шинэчлэсэн найруулгыг бид өөрсдөө батлах ёстой. Дүрмийн төсөлтэй танилцсан биздээ. Асуулт байна уу? Асуулт гарсангүй.

Д.Зандансүрэн: ТУЗ, Хянан шалгах зөвлөд нэр дэвшиж байгаа хүмүүс ирсэн байна. Тэднээс асуух зүйл байвал асууя.

Б.Содномцог: Бүгд л боловсролтой сайхан залуучууд байна. Компанийг цааш нь сайхан удирдаад явах байх гэж найдаж байна.

Саналын хуудсандаа саналаа тэмдэглээд өгье.

Д.Зандансүрэн: Одоо компанийн хөрөнгө худалдаа асуудалдаа орьё. Компанид цаашид шаардлагагүй болсон хөрөнгө болохоор худалдах нь зүйтэй гээд шийдвэрийн төслийг хуралдаанд танилцуулж байгаа юм байна.

Ч.Базардорж: Та нар одоо байгаа хөрөнгийн чанар байдлыг мэдэж байгаа. Цаашдаа ашиглах боломжгүй болсон. Ихээхэн хөрөнгө гаргаж засвар хийх хэрэгтэй. Зарсан нь дээр байх тэгээд ч одоо энд амьдарч уг хөрөнгийг ашиглах хувьцаа эзэмшигч ч алга болоод байна.

Д.Зандансүрэн: Компанийн нэр хаяг байршилыг өөрчлөх асуудал хэлэлцэхээр товлосон байгаа. Хаягийн өөрчлөлт дүрэмд тусгагдсан. Нэрийн өөрчлөлт хийхийг энэ хурлаар зөвшөөрөөд, ТУЗ-д бүрэн эрхийг нь өгье.

Одоо санал хураалтдаа орьё. Саналын хуудсаа бөглөөд **Б.Билгуунд** өгөөрэй.

Б.Билгуун саналын хуудсыг тоолоод дүн болон тооллогын комиссын тогтоолыг танилцуулав. Түүнийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолуудыг уншиж танилцуулан, баталснаар хурлын ажиллагаа 17 цаг 15 минутад дууслаа.



ХУРЛЫН ДАРГА

Д.ЗАНДАНСҮРЭН

**“АРХУСТ ШУНХЛАЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ
НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2010 оны 4 дүгээр сарын
14-ний өдөр

Дугаар 1

Төв аймаг

ТӨСӨЛ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 64.4 дэх заалт, 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын тооллогын комиссын 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн өнөөгийн байдлын тухай мэдээлэл болон үйл ажиллагааг сэргээх төслийг 1-р хавсралтаар баталсугай.



Д.ЗАНДАНСҮРЭН
Д.ЗАНДАНСҮРЭН

**“АРХУСТ ШУНХЛАЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ
НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2010 оны 4 дүгээр сарын
14-ний өдөр

Дугаар 2

Төв аймаг

**КОМПАНИЙН ДҮРМИЙН ШИНЭЧЛЭСЭН
НАЙРУУЛГЫГ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 63.1.1 дэх заалт, 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын тооллогын комиссын 2 дугаар тогтоолыг тус тус ундэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн үйл ажиллагааг сэргээн явуулах шийдвэр гаргасантай холбогдон компанийн дүрмийн шинэчлэсэн найруулгыг 2-р хавсралтаар баталсугай.
2. Дүрмийн шинэчлэсэн найруулгыг улсын бүртгэлд бүртгүүлэхийг гүйцэтгэх захирал /Г.Алтаймаа / -д үүрэг болгосугай



ХУРЛЫН ДАРГА

Д.Зандансүрэн
Д.ЗАНДАНСҮРЭН

**“АРХУСТ ШУНХЛАЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ
НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2010 оны 4 дүгээр сарын
14-ний өдөр

Дугаар 3

Төв аймаг

**КОМПАНИЙН ДОТООД ЖУРМУУДЫГ
ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 63.2.12, 76.1.13 дах заалт, 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын тооллогын комиссын 2 дугаар тогтоол, хувьцаа эзэмшигчдээс гаргасан саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн үйл ажиллагааг сэргээн явуулах төсөл батлагдсантай холбогдон “Монголын компанийн засаглалын кодекс”-т нийцүүлэн боловсруулсан компанийн долтоод журмуудыг хувьцаа эзэмшигчид санал нэгтэй зөвшөөрснийг тэмдэглэсүгэй.
2. Компанийн дотоод журмууд нь хуулиар хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулсан асуудалд багтахгүй, уг журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах бүрт компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах нь зохимжгүй гэж үзээд эдгээр журмуудыг батлах асуудлыг шинээр сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулсугай.



В.Зандсүрэн

Д.ЗАНДАНСҮРЭН

**“АРХУСТ ШУНХЛАЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ
НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2010 оны 4 дүгээр сарын
14-ний өдөр

Дугаар 4

Төв аймаг

ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 23.1 дэх заалт, 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын тооллогын комиссын 3 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Кумулятив аргаар санал хураахад хамгийн олон санал авсан дараах нэр бүхий 9 хүнийг компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгосугай.

| | |
|-------------------|-------|
| 1.1.Д.Амар | 72530 |
| 1.2.Б.Анар | 72530 |
| 1.3.Г.Нарангэрэл | 72530 |
| 1.4. Ц.Оюумаа | 72530 |
| 1.5. Ц.Сарантуяа | 72530 |
| 1.6. Ц.Баяараа | 72530 |
| 1.7.Г.Алтаймаа | 72530 |
| 1.8.Б.Отгонтуяа | 72530 |
| 1.9.Д.Нанжинчимэг | 72530 |

2. Компанийн хянан шалгагчаар нэр нь дэвшиж, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналыг авсан С.Сэлэнгийг компанийн хянан шалгагчаар сонгосугай..

3. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллахыг ТУЗ-ийн гишүүд, хянан шалгагчид үүрэг болгосугай.



А.Зандансүрэн

Д.ЗАНДАНСҮРЭН

**“АРХУСТ ШУНХЛАЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ
НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2010 оны 4 дүгээр сарын
14-ний өдөр

Дугаар 5

Төв аймаг

**КОМПАНИЙН ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙГ
ХУДАЛДАХ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ**

Компанин тухай хуулийн 89.1 дэх заалт, 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын тооллогын комиссын 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн үл ажиллагааг сэргээн явуулах төсөл батлагдсантай холбогдон компанийд цаашид шаардлагагүй болсон үл хөдлөх хөрөнгийг худалдах тухай шийдвэрийг бүх хувьцаа эзэмшигчид санал нэгтэй зөвшөөрснийг тэмдэглэсүгэй.
2. Компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдах тухай шийдвэр нь Компанийн тухай Монгол улсын хуулийн 86.2-т заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул уг хэлцлийг батлах, хэлцлийн үнийг тогтоох асуудлыг шинээр сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулсугай.



ХУРЛЫН ДАРГА

Д.ЗАНДАНСҮРЭН

Д.ЗАНДАНСҮРЭН

**“АРХУСТ ШУНХЛАЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ
НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2010 оны 4 дүгээр сарын
14-ний өдөр

Дугаар 6

Төв аймаг

Компанийн нэрийг өөрчлөх тухай

Компанийн тухай хуулийн 23.1 дэх заалт, 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын тооллогын комиссын 3 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн нэрийг өөрчлөх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх эрхийг төлөөлөн удирдах зөвлөлд шилжүүлсүгэй.



Д.Зандансүрэн

Д.ЗАНДАНСҮРЭН

**“АРХУСТ ШУНХЛАЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2010 оны 4 дүгээр сарын
14-ний өдөр

Дугаар 1/01

Төв аймаг

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 78.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. ТУЗ-ийн хуралд оролцсон нийт 9 гишүүний 100%-ийн саналаар Д.Нанжинчимэгийг ТУЗ – ийн даргаар сонгосугай.
2. ТУЗ-ийг удирдан зохион байгуулж, компанийн тухай хууль, компанийн дүрэм, засаглалын дотоод журмаар тогтоосон үүргээ хэрэгжсүүлэн ажиллахыг ТУЗ-ийн дарга Д. Нанжинчимэгт даалгасугай.



Д.Нанжинчимэг
Ганбаатар Нарангэрэл
Цагдаач Оюумая
Д.Нанжинчимэг
Бурэнхүү Анаар
Цэвэгсүрэн Сарантуюя
Цэдэндамбаа Баяраа
Гунаажав Алтаймая
Бадамдорж Отгонтуяа

ДУНГАРМАА АТАР

ГАНБААТАР НАРАНГЭРЭЛ

ЦАГААЧ ОЮУМАА

Д.НАНЖИНЧИМЭГ

БҮРЭНХҮҮ АНААР

ЦЭВЭГСҮРЭН САРАНТУЯА

ЦЭДЭНДАМБАА БАЯРАА

ГУНААЖАВ АЛТАЙМАА

БАДАМДОРЖ ОТГОНТУЯА

**“АРХУСТ ШУНХЛАЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2010 оны 4 дүгээр сарын
14-ний өдөр

Дугаар 1/08

Төв аймаг

**КОМПАНИЙН ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙГ
ХУДАЛДАХ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 85.1 болон 89.1 дэх заалт, хувь нийлүүлэгчдийн хурлын 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 5 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн гүйцэтгэх захиралаас оруулсан саналыг дагуу компанийн үйл ажиллагаанд цаашид шаардлагагүй болсон үл хөдлөх хөрөнгийг хавсралтын дагуу мөн хавсралтад дурьдсан үнээр худалдахыг гүйцэтгэх захирал /Г.Алтаймаа/-д зөвшөөрсүгэй.
2. Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийг шилжүүлэх ажиллагааг энэ шийдвэрийн дагуу хэрэгжүүлэхийг үл хөдлөх хөрөнгийг худалдан авсан хувьцаа эзэмшигчдэд үүрэг болгосугай.



ТУЗ-ийн ДАРГА
ТУЗ-ийн ГИШҮҮД

Д. НАНЖИНЧИМЭГ
ДУНГАРМАА АТАР

ГАНБААТАР НАРАНГЭРЭЛ

Оюумж ЦАГААЧ ОЮУМАА

Баяр БҮРЭНХҮҮ АНАР

Цэвэгсүрэн САРАНТУЯА

ПЭДЭНДАМБАА БАЯРАА

ГУНААЖАВ АЛТАЙМАА

БАДАМДОРЖ ОТГОНТУЯА

**“АРХУСТ ШУНХЛАЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2010 оны 4 дүгээр сарын
14-ний өдөр


Дугаар 1/04

Төв аймаг

**КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ
СОНГОН ТОМИЛОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 76,1,8 д зааснаар ТУЗ ийн дарга Д. Нанжинчимэгийн санал оруулсныг үндэслэн хэлэлцээж ТОГТООХ НЬ:

- Хуралд оролцсон нийт 9 гишүүний 100% - ийн саналаар Г. Алтаймааг гүйцэтгэх захирлаар сонгон томилсугай.
- Компанийн тухай хууль болон холбогдох хууль журмуудын хүрээнд, мөн ТУЗ – эй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллахыг гүйцэтгэх захирал Г. Алтаймаад үүрэг болгосугай.



ТУЗ-ийн ДАРГА
ТУЗ-ийн ГИШҮҮД

Д. НАНЖИНЧИМЭГ
ДУНГАРМАА АТАР

ГАНБААТАР НАРАНГЭРЭЛ

ЦАГААЧ ОЮУМАА

БҮРЭНХҮҮ АНАР

ЦЭВЭГСҮРЭН САРАНТУЯА

ЦЭДЭНДАМБАА БАЯРАА

ГУНААЖАВ АЛТАЙМАА

БАДАМДОРЖ ОТГОНТУЯА